



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот


Сургалтын төрийн сангийн зээлийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны "Журам батлах тухай" 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторонтурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам" –ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны А/155 тоот тушаалын Жаргалсайхан Баасанжавын холбогдох хэсгийн АНУ-ын "Мичиганы их сургууль" гэснийг "Миннесота их сургууль" гэж өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл хөтөлбөр, гадаад хамтын ажиллагааны газар /Э.Энх-Амгалан/-т тус тус даалгасугай.

САЙД



Г.ЧУЛУУНБААТАР